



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/33 дугаар захирамж, 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад пийшин зуухны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, агаар бохирдуулагч гуравдагч эх үүсвэр түлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, судалгаа гаргах, зөвлөгөө өгөх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Хяналт шалгалт хийх, судалгаа гаргах, зөвлөгөө өгөх албан хаагчдыг хавсралтаар баталсугай.

3.Хяналт шалгалтаар ажиллах албан хаагч хоолны мөнгө, шатахууны зардал болох 660,000 (зургаан зуун жаран мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн
А/02 дугаар тушаалын хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ, СУДАЛГАА ГАРГАХ,
ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

д/д	Албан тушаал	Овог, нэр
1	Бодлогын баримт бичгийн тайлан, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	Очирбатын Нямбат
2	Сургалт, судалгаа, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Чулуунбаатарын Энх-Отгон
3	Эвент хариуцсан мэргэжилтэн	Бямбадоржийн Үржинханд
4	Эвент хариуцсан мэргэжилтэн	Түвшинжаргалын Батдорж
5	Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер	Тулгын Мэргэн
6	Цахим хөгжүүлэлт, мэдээллийн технологи хариуцсан ажилтан	Бат-Оргилын Энхтайван
7	Архив бичиг хэргийн эрхлэгч	Дэлгэрсайханы Дэлгоржав
8	Мэдээллийн төвийн ажилтан	Батсайханы Баганбанди
9	Мэдээллийн төвийн ажилтан	Баярын Билэгт